

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР



КОРОНАВИРУС /КОВИД-19/ ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

УЛААНБААТАР ХОТ

2020 ОН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: КОРОНАВИРУС /КОВИД-19/ ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР

БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод анх бүртгэгдсэн шинэ төрлийн коронавирусын халдвар хүрээгээ тэлж Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ)-ын олон улсад халдвар тархан “Олон улсын нийгмийн эрүүл мэндийн онц ноцтой байдал” хэмээн зарласан. Дэлхий дахинд үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг 2020 оны 2 дугаар сарын 13-наас эхлэн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” /хэсэгчлэн/ шилжүүлсэн.

Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд НЗЗ-ны 5-н байр, НҮНТөвийн 4-н салбар болон Баянхүшуу дэд төвийн байруудын цэвэрлэгээ, үйлчилгээг нэмэгдүүлж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хуваарийн дагуу хийж, төрийн албан хаагчид болон төрийн үйлчилгээг авч буй иргэдэд өвчлөлийн байдлын талаар ухуулга, сурталчилгааг байрлуулан, мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүргэн, албан хаагчдад амны хаалт хэрэглэх, гар ариутгах, дархлаа дэмжих талаар зөвлөмжүүдийг хүргэхээс гадна бага насны буюу 12 хүртэлх насны хүүхэдтэй ажилтан, албан хаагчдын ажлын цагийг хорогдуулан тооцож, ажил үүргээ цахимаар хийж гүйцэтгэх нөхцөл боломжоор ханган ажилласан.

Мөн иргэдэд зөвлөмж мэдээлэл өгч, гаднаас нэвтрэх иргэд, албан хаагчдын халууныг хэмжин, амны хаалттай дотогш нэвтрүүлэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

Нэг. Удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах чиглэлээр:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын “Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168 дугаар захирамжуудыг тус тус үндэслэн:

- Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр А/12 дугаар тушаал “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хариу арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, бэлэн байдлыг хангах тухай”;

- 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдөр А/13 дугаар тушаал “Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар хэрэгжүүлж буй арга хэмжээнд хяналт тавих хуваарь батлах тухай”;

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 62, 63 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 1, 2, 3 дугаар хурлын тэмдэглэл, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны А/274 дүгээр тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 2, 3, 4 дүгээр “Ажлын хэсэг”-ийн 1 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/108, А/166, А/168, А/191 дүгээр захирамж, Газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.7 дахь заалтыг тус тус үндэслэн:

- 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/14 дүгээр тушаал “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан ажлын тусгай горимд шилжүүлэх, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай”;

- 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/15 дугаар тушаал “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хариуцлагатай эргүүл, жижүүр томилох тухай”;

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 30, 62, 64 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “12 хүртэлх насны хүүхэдтэй эхчүүдийн ажлын цагийг хорогдуулах тухай” А/268 дугаар захирамжийг тус тус үндэслэн:

- 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/18 дугаар тушаал “Шинэкоронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд зарим ажилтан, албан хаагчдын хорогдуулсан цагаар ажиллуулах тухай”;

Улсын Онцгой комиссын 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 06 дугаар тогтоол, Нийслэлийн Онцгой комиссын 08 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/268 дугаар захирамжийг тус тус үндэслэн:

- 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/19 дүгээр тушаал “Коронавируст халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зарим ажилтан, албан хаагчдад цалинтай чөлөө олгох, хорогдуулсан цагаар ажиллуулах тухай” тус тус батлан гаргасан.

2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/14 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”, хоёрдугаар хавсралтаар “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газраас шинэ коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан холбогдох удирдлагад үүрэг чиглэл өгч, хариуцсан ажилтан, албан хаагчдаар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, хэрэгжилтэд хяналт тавих зэргээр удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа.



Зураг 1. Байр хариуцсан менежерүүдэд заавар, зөвлөгөө өгч буй байдал

Шинэ коронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хувцас, ариутгалын бодисоор ханган, шаардлагатай нөөцийг бүрдүүлэн ажилласан.



Зураг 2. Шаардлагатай хэрэгслэлийн нөөцлөлт

Хоёр. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар нь шинэкоронавируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны 5-н байр, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 4-н салбар болон Баянхошуу дэд төвийн байруудад ажиллаж буй төрийн албан хаагчид, үйлчилгээ авч буй иргэдэд тогтмол амны хаалт зүүх шаардлага тавьж, зөвхөн амны хаалт зүүсэн төрийн албан хаагч, иргэдийн халууныг хэмжин, гар ариутгагч спиртэн суурьт халдваргүйжүүлэлтийн уусмалаар гарыг ариутган нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан бүрэн хэвшүүлэн ажилласан.



Зураг 3. Халууныг тогтмол хэмжин, гар ариутгагч хэрэглүүлж нэвтрүүлж буй явц

Нийслэлийн засаг захиргааны байруудын нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн өрөөнд гар ариутгагч спиртэн суурьт халдваргүйжүүлэлтийн уусмалыг байршуулан ажилласан бөгөөд халдвараас урьдчилан сэргийлэх цаасан зөвлөмжийг нийтийн эзэмшлийн талбайд ил тод байршуулан, урьдчилан сэргийлэх зөвлөгөөг видео хэлбэрээр дэлгэцээр тогтмол хүргэн ажилласан.



Зураг 4. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг ил тод байрлуулсан байдал

НЗЗ-ны 5-н байр, ННҮТөвийн 4 салбарын болон Баянхошуу, Сэлбэ дэд төвийн нийт 47.503.74м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа халдваргүйжүүлэх бодисыг шинээр найруулан шат, цахилгаан шат, хаалганы бариул, хаалга, ширээ сандал, компьютерийн гар, хулгана, суурин утас гэх мэт хүний байнга хүрэх хатуу гадаргууг 0.015%-ийн жавелионы уусмалаар, ариун цэврийн өрөөнүүдийг 0.03%-ийн жавелионы уусмалаар 2 цаг тутам шүршиж, чийгтэй цэвэрлэгээг хийн халдваргүйтгэж ажилласан.





Зураг 5. Хувийн хамгааллыг ханган цэвэрлэгээ үйлчилгээг хийж буй явцаас

Байрууд гаднах орчны аюулгүй байдлыг хангах үүднээс байруудын гадна орчны нийт 2700м² талбайд 12 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ, үйлчилгээг хийж, ариутгал халдваргүйжүүлэлтийг хийлээ. Олон нийтийн газар нус, цэр, шүлсээ хаяхгүй, ил задгай хог хаягдлаар орчноо бохирдуулахгүй байх санамжийг тус тус байршуулж ажиллалаа.



Зураг 6. Байруудын гадна талбайд цэвэрлэгээ үйлчилгээг хийж буй байдал



Зураг 7. Байруудад бэлэн байдлыг ханган ажиллаж буй байдал

Коронавирусын халдвараас ард иргэдийг хамгаалах зорилгоор НЗДаргаас өгсөн үүрэг чиглэл, хуваарийн дагуу байгууллагын 260 ажилтан, албан хаагч 02 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдөр хүртэлх хугацаанд ХУД-ын 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт “Эргүүл”-ийн албан үүргийг гүйцэтгэн 3844 аж ахуй нэгж, иргэдэд амны хаалт тогтмол зүүх талаарх ЭМЯамнаас өгсөн заавар зөвлөмжийг өгч, гарын авлага материалыг тараах, гудамж, олон нийтийн газраар сэлгүүцэхгүй байх зөвлөгөөг өгөн, аж ахуй нэгж байгууллагуудад ариутгал халдваргүйтгэл хийгдсэн эсэхэд хяналт тавин ажилласан. Тус хугацаанд тухайн нутаг дэвсгэрт гарсан ноцтой зөрчил байхгүй бөгөөд иргэд төр засгаас гаргасан шийдвэр, зөвлөгөөг хүндэтгэн эргүүлээр ажиллаж буй төрийн албан хаагчдын тавьсан шаардлагыг хүлээн авч амны хаалтаа тогтмол зүүж хэвшсэн. Эргүүлтэй холбоотой тайлан, мэдээг өдөр тутам ХУДүүргийн Онцгой комисст хүргэн ажилласан.



Зураг 8. Эргүүлээр ажиллаж буй байдал

Халдварт цар тахал дэгдсэнтэй холбогдуулан 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Өлзийт, Баянзүрхийн шалган нэвтрүүлэх товчоодод тус газрын 3 ажилтан 24 цагаар үүрэг гүйцэтгэн ажилласан.



Зураг 9. Шалган нэвтрүүлэх товчоонд ажиллаж буй төрийн албан хаагчдад хоол цайгаар үйлчиллээ

Нийслэлийн нутаг дэвсгэрт “Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулилтын бэлтгэл ажлыг хүрээнд 2020 оны 05 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд 24 ажилтны бүрэлдэхүүнтэйгээр Буянт-Ухаа спортын ордонд 300 ортой эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн хэсэг, үйлчлүүлэгчдийн хувцас солих өрөө, хоолны өрөөний хаягжилт, дуугүй хөтөч тэмдэг тэмдэглэгээг хийж тохижуулж газрын цэвэрлэгээ үйлчилгээг хийж, бэлэн байдлыг ханган холбогдох албаны удирдлагуудад хүлээлгэн өгсөн.





Зураг 10. Халдварт цар тахлын үед ажиллахад зориулагдсан 300 ортой эмнэлгийн бэлтгэл ажлыг ханган удирдлагуудад хүлээлгэн өгч буй үе

“Ковид-19 халдварт цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” сэдэвт дадлага сургуулилт 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдаж, НЗЗ-ны 4-н байранд өндөржүүлсэн бэлэн байдлын тусгай хувцас хэрэглэлийг өмссөн 13 ажилтан орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хязгаарлах арга хэмжээг авч, хөл хорионы дэглэмийг сахиулан ажиллалаа.



Зураг 11. Сургуулилтын үеэр өндөржүүлсэн бэлэн байдлаар ажиллаж буй байдал

НЗЗ-ны 2 дугаар байрны үйлчилгээний ажилтнуудыг санаачилгаар “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан байгууллагын ажилтан, албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор витаминжуулалтын ажлыг зохион байгуулсан.



Зураг 12. Витаминжуулалт хийж буй байдал

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын баталсан “Амны хаалтаа зүүцгээе” аяны хүрээнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан “Амны хаалт-Таны баталгаа” чэлленж хөдөлгөөнийг өрнүүлэн НЗЗ-ны байруудад үйл ажиллагаа явуулдаг төрийн албан хаагч нарыг уриалан видео хэлбэрээр уриалга гарган олон нийтийн сүлжээнд байршуулан ажилласан. Тус тайланг 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр НЗДТГ-т хүргүүлсэн.



Зураг 13. Тус чэлленж хөдөлгөөний үед зохиогдсон арга хэмжээний үеэр

Гурав. Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар:

Халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр Монголын ариутгал халдваргүйжүүлэлтийн холбоо ТББ-ын тэргүүн Н.Баасанжавыг урин “Коронавирус халдварын сэргийлэлт, хяналт” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад нийт 35 ажилтан, албан хаагч хамрагдсан.



Зураг 14. Сургалтын үеэр

Байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийн нэмэгдүүлэн гарын шингэн саван, гар ариутгагч байрлуулсан. Ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, байруудын гадна, дотор орчны 47.503.74м.кв талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам хийж гүйцэтгэж мэргэжлийн байгууллага “Түвшин төгөлдөр” ХХК-тай хамтран ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн хүний биед элдэв харшил өгөхгүй, ногоон байгууламжийг устгаж сүйтгэхгүй зориулалтын бодис ашиглан, мананцар үүсгэгч ариутгалын аппаратаар байруудын нийтийн эзэмшлийн талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэн ажилласан.





Зураг 15. Нийслэлийн Засаг захиргааны байруудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй явцаас



Зураг 16. Төрийн албаны шалгалтын үеэр

Дөрөв. Өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн үйл ажиллагааны явцад хяналт тавин ажилласан талаар:

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын даргын баталсан удирдамжийн дагуу НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын цэвэрлэгээ, үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хэрэгжилтэд 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 05 дугаар сарын 18-ны өдрүүдэд хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: КОРОНАВИРУС /КОВИД-19/ ЦАР ТАХАЛ ГОЛОМТОЛОН ҮҮССЭНТЭЙ ХОЛБООТОЙГООР ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ, ХАРИУ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЛААР

Нэг. Удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах чиглэлээр:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.1, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242 дугаар захирамжийг тус тус үндэслэн:

- 2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/61 дүгээр тушаал “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний арга”;

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 181 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 34 дүгээр хурлын тэмдэглэл,

Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 16 дугаар хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242, 1250 дугаар захирамжийг тус тус үндэслэн:

- 2020 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/63 дугаар тушаал “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хатуу хөл хорионы дэглэмийн үед ажлын хариуцлагыг сайжруулах тухай”;

Газрын хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.1, 2.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн:

- 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/64 дүгээр тушаал “Шуурхай баг томилох тухай”;
- Гамшгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.4.2, 10.4.10, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай” 194 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 37 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн:
- 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/65 дугаар тушаал “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан ажлын тусгай горимд шилжүүлэн ажиллуулах тухай”;

Засгийн газрын 2020 оны 226 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 3728 дугаар албан бичиг, Нийслэлийн Засаг даргын А/1320 дугаар захирамжийг тус тус үндэслэн

- 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/72 дугаар тушаал “Зайнаас ажиллах түр журам батлах тухай” тус тус батлан гаргасан.

2020 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/61 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээний удирдамж”, хоёрдугаар хавсралтаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед коронавируст /ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан холбогдох удирдлагад үүрэг чиглэл өгч, хариуцсан ажилтан, албан хаагчдааар төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулан, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих зэргээр удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллалаа. Тус төлөвлөгөөний 2020 оны биелэлтийг 7 хоног бүр гарган нэгтгэж удирдлагад танилцуулан ажилласан.

НЗЗ-ны 1, 2 дугаар байруудад Нийслэлийн Онцгой комисс, нутгийн захиргааны зарим байгууллагуудын ажилтан, албан хаагчид ажиллаж байгаатай холбогдуулан коронавируст /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллаж буй байгууллагын ажилтан, албан хаагчдыг хамгаалах хувцас, ариутгалын бодис хэрэглэлээр ханган ажилласан. Мөн тус байруудаас шаардлагатай хэрэгсэл, ариутгалын бодисны нэмэлт захиалгыг авч, нөөц бүрдүүлэлтийг хангаж ажилласан.



Зураг 17. Даргын тушаалын дагуу ажилтан, албан хаагчдын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийн ажиллаж байна

Цар тахлын үед 9-н байршлын аюулгүй байдлыг хангаж, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйтгэл, зоогийн үйлчилгээг чанартай, тасралтгүй, хэвийн, найдвартай явуулах үүднээс үйлчилгээнд ажиллаж буй ажилтнуудад халдвар хамгааллын хэрэгслийг шаардах хуудсаар бүрэн олгож, шаардлагатай хамгаалалтын хэрэгсэл, цэвэрлэгээний бодис, ариутгал халдваргүйтгэлийн тоног төхөөрөмж болон түүний бодисны нөөцлөлтийг тайлант хугацаанд нийт 44.468.958 төгрөгний бүрдүүлэлт хийж ажилласан. Үүнд:



Угтах үйлчилгээний ажилтан болон байр хариуцсан менежерүүдэд:

- Амны хаалт
- Нэг удаагийн бээлий
- Нэг удаагийн малгай
- Нэг удаагийн хамгаалалтын хувцас
- Ариутгагч спирт
- Гар ариутгагч гел
- Халуун хэмжигч



Цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтанд:

- Амны хаалт
- Нэг удаагийн малгай
- Ариутгалын бодис
- Ариутгагч спирт
- Гар ариутгагч гел



Зоогийн үйлчилгээний ажилтанд:

- Амны хаалт
- Нэг удаагийн малгай
- Хүнсний бээлий
- Ариутгагч спирт
- Гар ариутгагч гел
- Нүүрний хамгаалалтын хэрэгсэл



Ариутгал халдваргүйжүүлэлт хийж буй ажилтанд:

- Амны хаалт, 1 удаагийн бээлий, малгай
- Нүүрний хаалт
- Нэг удаагийн хамгаалалтын хувцас
- Ариутгагч спирт
- Гар ариутгагч гел
- Ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис
- Ариутгалын төхөөрөмж
- One step /Гишгээд гараа ариутгадаг төхөөрөмж/
- Смарт хаалганы ариутгалын бодис

Зураг 18. Шаардлагатай нөөц бүрдүүлэлтийг ажлын байр бүрээр үзүүлбэл


Газрын даргын А/64 дүгээр тушаалаар “Шуурхай баг” томилогдсон бөгөөд тус багийн ажилтнууд 24 цагаар ээлжлэн ажиллаж, нийслэлийн засаг захиргааны байруудын инженерийн байгууламжийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг ханган ажилласан.

Тухайлбал хатуу хөл хорионы үед Баянхошуу дэд төвийн усны хэрэглээ зогссонтой холбоотойгоор хэрэглээний хүйтэн усны гадна шугам худгаас барилга хүртэлх 16 метр зайд хөлдөж, хэрэглээний халуун, хүйтэн усны дотор шугам ариун цэврийн өрөөний хананд байрлах шахтын хөндийд PPR Ф15 диаметртай босоо шугам хоолой хөлдсөнийг 2020 оны 11 дүгээр сарын 21-нээс 22-ны шилжих шөнө Байр ашиглалтын албаны “Гамшгаас хамгаалах шуурхай баг” 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр очиж, уураар халааж хөлдөнгийг гэсгээж, хэрэглээний халуун, хүйтэн усны шугамыг хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан.



Зураг 19. Шуурхай багийн үйл ажиллагааны явцаас

Коронавируст /Ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд нийслэлээс авч хэрэгжүүлж ажиллаж буй мэдээлэл болон өдөр тутамд хэрэгжүүлж буй ажлын мэдээлэлийг “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар” фэйж хуудас, “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар-2018” фэйсбүүк хуудаст тухай бүр байршуулан мэдээлж ажиллалаа.



Зураг 20. Байрууд дээр хийгдэж буй үйл ажиллагааг байршуулсан байдал

Хоёр. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Монгол улсын Засгийн газрын 181 дүгээр тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан газрын даргын А/63 дугаар тушаал батлагдсан. Монгол улсын Засгийн газрын 181 дүгээр тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан газрын даргын А/63 дугаар тушаал батлагдсан. Уг тушаалын дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хатуу хөл хорионы дэглэмийн үед ажлын хариуцлагыг сайжруулах талаар арга хэмжээ авч, нийслэлийн засаг захиргааны байруудаар зайлшгүй шаардлагаар нэвтэрч буй ажилтан, албан хаагчдыг иргэний үнэмлэхний QR кодоор бүртгэлжүүлэн нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан. Тайлант хугацаанд тус тус байруудад сэжигтэй тохиолдол илрээгүй байна.



Зураг 21. Халдвар хамгааллыг сахин нэвтрүүлж буй үйл явцаас

Коронавируст /ковид-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр нийслэлийн засаг захиргааны 1, 2 дугаар байруудад автомат халуун үзэгч, ариутгагч смарт хаалга байрлуулж нэвтрүүлдэг боллоо. Ингэснээр тус байруудад ажиллаж буй төрийн албан хаагчдыг нэвтрүүлэхэд бидний ажил үүргийг илүү хөнгөвчилсэн үр дүнтэй, түргэн шуурхай, найдвартай болж байгаа юм.



Зураг 22. Бүртгэл хөтлөн, халууныг хэмжин, смарт хаалгаар нэвтрүүлж буй явцаас

Байруудын ариун цэврийн ерөөний цэвэрлэгээ үйлчилгээг онцгойлон анхааран, ажлын ерөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, гадна, дотор орчны нийт байруудын 41.636 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам тогтмол хийж гүйцэтгэсэн. Мөн байр ашиглалтын албаны лифтчид НЗЗ-ны 2, 4-р байрны цахилгаан шатыг 1 цаг тутамд ариутган, хэвийн аюулгүй ажиллагааг бүрэн ханган ажилласан.



Зураг 23. Лифтны ариутгал, халдваргүйжүүлэлт

Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн үүрэг чиглэлийн дагуу төрийн байгууллагад сэжигтэй тохиолдол илэрсэн үед ашиглах, тусгаарлах өрөөг 12 байршилд бэлтгэн коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж байна.



Зураг 24. Тусгаарлах өрөөг бэлэн болгосон байдал

Зоогийн газрын хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийг гэрээт байгууллагатай хамтран баталгаат хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, тус хугацаанд хатуу хөл хорионы үед зөвхөн НЗДТГазрын зоогийн газар нь 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Нийслэлийн Онцгой комиссын 120 хүний бүрэлдэхүүнд өдөрт 2 удаа хоол зоогийн үйлчилгээг халдвар, хамгааллын дэглэмийг чанд мөрдөн ажилласан.



Зураг 25. НОК-ын ажилтан, албан хаагчдад хоол, цайгаар үйлчилж буй явцаас

Нийслэлийн Засаг даргын А/1280 “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр зааврыг мөрдлөг болгон ажиллаж нийслэлийн нутгийн захиргааны байруудад байрлах нийслэлийн харьяа байгууллагад ажиллаж буй ажилтан, албан хаагчдын халдвартай хүн асарсан, хавьтал болсон талаарх халдварын эрсдэлийг үнэлэх зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 14-18-ны хооронд 5 өдрийн хугацаанд “Асуумж судалгаа”-г www.erp.ulaanbaatar.mn/ авч дүнг нэгтгэсэн. Судалгаанд 847 албан хаагч хамрагдсан.



График 1. Ажилтан, албан хаагчдын халдвартай хүн асарсан, хавьтал болсон талаарх халдварын эрсдэл үнэлэх асуумж

Байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээг онцгойлон анхааран, ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, гадна, дотор орчны нийт байруудын 41.636 м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам тогтмол хийж гүйцэтгэсэн.



Зураг 26. Цэвэрлэгээ үйлчилгээ хийж буй явцаас

НЗДТГазраас НЗДТГазар, НИТХурлын ажилтан, албан хаагчдыг PCR шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулсан бөгөөд тус байгууллагаас нийт 5 албан хаагч бүртгэж, зохион байгуулалан ажиллаж, шинжилгээнд хамрагдсдын мэдээг нэгтгэн ХӨСҮТөвд өгч ажилласан. Байгууллагын нийт ажилтан, албан хаагчдыг өөрийн оршин суух дүүрэг, хороонд харьяаллын дагуу коронавирусийн PCR шинжилгээнд хамрагдах үүрэг өгсөн ба 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар 277 ажилтан, албан хаагч шинжилгээнд хамрагдсан.



Зураг 27. Тус чэлленж хөдөлгөөний үед зохиогдсон арга хэмжээний үеэр

Гурав. Ариутгал халдваргүйжүүлэлтийн талаар:

Байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийн нэмэгдүүлэн гарын шингэн саван, гар ариутгагч байрлуулсан. Ажлын өрөөний өдөр тутмын цэвэрлэгээ үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлж, байруудын гадна, дотор орчны 41.636м2 талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг 2 цаг тутам хийж гүйцэтгэж мэргэжлийн байгууллага “Түвшин төгөлдөр” ХХК-тай хамтран ДЭМБ-аас зөвшөөрөгдсөн хүний биед элдэв харшил өгөхгүй, ногоон байгууламжийг устгаж сүйтгэхгүй зориулалтын бодис ашиглан, мананцар үүсгэгч ариутгалын аппаратаар байруудын нийтийн эзэмшлийн талбайд ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэн ажилласан.





Зураг 28. Нийслэлийн Засаг захиргааны байруудад ариутгал, халдваргүйжүүлэлт хийж буй явцаас



Зураг 29. Хурлын заал, уулзалтын өрөөний ариутгал, халдваргүйжүүлэлт



Зураг 30. НОКомиссын байрлаж буй өрөө, тасалгааны ариутгал, халдваргүйжүүлэлт



Зураг 31. Байруудын гадна талбайн ариутгал, халдваргүйжүүлэлт



Зураг 32. Жилийн эцсийн байдлаар нийт 47,503,74 мкв талбайд ариутгал, халдваргүйжүүлэлт хийгдсэн

Дөрөв. Бүх нийтийн бэлэн байдлын үеийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж ажилласан талаар:

Газрын даргын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/60 дугаар “Коронавируст /ковид-19/ цар тахлын халдвар, тархалтаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” тушаалаар нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд, дэд төвүүдийн цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахад хяналт тавин ажиллах албан хаагчдын хуваарийг гаргаж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Тайлант онд дэлхий нийтэд Коронавирус /Ковид-19/ цар тахал дэгдэсэнтэй холбогдуулан урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний чиглэлээр гаргасан Засгийн газрын тогтоол, Улсын Онцгой комиссын тогтоол, хурлын тэмдэглэл, Нийслэлийн Засаг даргын захирамж, Нийслэлийн Онцгой комиссоос гаргасан аливаа шийдвэрийн дагуу байгууллагын үйл ажиллагааг уялдуулан, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад ажиллаж буй нийт ажилтан, албан хаагчид, тэдгээрээс төрийн үйлчилгээ авч буй иргэдийн эрүүл аюулгүй байдлыг ханган ажиллахаар зохион байгуулан ажилласан.

Мөн манай байгууллага нь цар тахлын бүх нийтийн бэлэн байдлын үед дүрмээр хүлээсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэн ажиллаж, цаг үеийн шинж чанартай дээд газраас зохион байгуулсан арга хэмжээнд идэвх санаачилгатай хамрагдан, өгөгдсөн үүрэг чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлэн ажиллалаа.

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН БИЧСЭН:
ДОТООД АЖИЛ, СУРГАЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

Ц.ҮРЭЛМАА